

Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ



Номын сангийн  
мэдээ



Санхүүгийн тайлан  
мэдээ



4-р сарын тайлан



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

2021.04.30

# ТООН ҮЗҮҮЛЭЛТ

НИЙТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

20

ХҮЛЭЭН АВСАН  
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД

+ 6

## Хүйс



Эмэгтэй

15



Эрэгтэй

5

## Тайлбар

Энэ сард 6 үйлчлүүлэгч хүлээн авч, өнөөдрийн байдлаар 20 үйлчлүүлэгч үйлчилгээнд хамрагдаж байна.  
Үүний 5 хүү, 15 охин байна.

4-р сарын тайлан

Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# ХЭРЭЭСЭН ХАТГАМАЛ



## Тайлбар

Ид шидийн орон хүүхдийн түр хамгаалах байраар үйлчлүүлж буй хүүхдүүдэд ТХБ-ны зохицуулагч Б.Аззаяа хэрээсэн хатгамал болон шигтгээ наамал зааж өгч, үйлчлүүлэгчид урам зоригоор дүүрэн оёж байна.

Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# 112 УДААГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

## Тайлбар

Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч хүүхүүд маань хөгжлийн хөтөлбөртөө тогтмол хамрагдаж байгаа хамгааллын багийн зүгээс 112 удаагийн хөгжлийн хөтөлбөрийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Сургалтуудаас дурдвал:

- Баруун зүүн тархийг хөгжүүлэх сургалт
- Найзаа хүндлэх дүрэм
- Хэл яриа зүгшрүүлэх
- Бүжиг
- Йога
- Цаг агаарт тохируулан хувцаслах
- Чухал шаардлагатай утасны дугаар
- Англи хэл
- Амьтадтай танилцъя
- Тоо нүдэлье
- Цахим орчны зөв зохистой хэрэглээ
- Миний биеийн аюулгүйн дүрэм



Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч хүүхдүүд маань дэмжих бүлгийн сургалтандаа хамрагдаж байгаа бөгөөд хамгааллын багийн зүгээс 26 удаагийн сургалтаныг зохион байгуулсан.

Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# ЦЭВЭРЧ ХҮҮХДҮҮД

## Тайлбар

Хөл хориотой ийм цаг үед бага насны 3 үйлчлүүлэгч маань тоглоомын өрөөний тоглоомоо содатай усаар угааж өөрсдийн болон бусад хүүхдүүдийн эрүүл мэндэд анхаарч байгаа нь



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# ТӨРСӨН ӨДРҮҮД

## Тайлбар

Энэ сард төрсөн өдрийн баяр нь тохиож байгаа  
5 үйлчлүүлэгчийн төрсөн өдрийг нь тэмдэглэн өнгөрүүлсэн.



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# 7-Г НЬ НАЙЗУУДДАА

Ид шидийн орон түр хамгаалах байранд байгаа үйлчлүүлэгчид маань урьдчилан сэргийлэх хяналтын үзлэгт тогтмол хамрагдаж байгаа. Үзлэгтээ ороод гарах болгонд нь витамин өгөөд гаргадаг, хүүхдүүд ч витаминаа авья гээл дуртай байдаг юм.

Нэгэн 6 настай үйлчлүүлэгч маань үзлэгтээ орж байгаад ийм яриа өрнүүлэв:

Ү: Багшаа өнөөдөр хэдэн витамин өгч байгаа вэ?

Б: 8 витамин өгч байгаа

Ү: Аан 8 уу /гээд бодлогширон суув/

Б: Ммхан яасын

Ү: Аан би хамт тоглож байгаа найзууддаа өгөх гээд

/хуруу даран найзуудынхаа нэрийг хэлээд тэрэнд нэгийг, тэрэнд нэгийг гээд тоолтол өөрт нь үлдсэнгүй шүү/

Б: Найзууддаа өгч яахнав өөрөө идээ найзууд нь бүгдээрээ үзүүлээд өөрөө өөрийнхөө витаминг аваад идцэн юм чинь

Ү: 2 найзын нэрийг хэлээд надаа витаминаасаа өгсөн юм аа одоо би бас өгнө

Б: Тиймүү тэгээд найзууддаа өгөөд чамд үлдсэнгүй шүү дээ

Ү: Зүгээрээ /инээв/



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# НЭГИЙГ НЬ ӨӨРТӨӨ +4

Бид 2-н үзлэг дуусч үйлчлүүлэгч маань 2 гараа тосон суухад нь өмнө хэлсэн нэрсийн дарааллаар нь за энийг тэрэнд, энийг тэрэнд гээд тоолоод өгтөл 7 найз болж нэг витамин үлдэв.

Б: Өө өгөх найзууд нь болцон уу? Нэг үлдчихлээ шүү дээ

Ү: Харин тиймээ болчих шиг л боллоо, үлдсэн нэгийг нь би өөрөө идье дөө /витамингүй хоцрох шахаж байсан хүүхэд маань их л баяртай инээв/

Б: За тэг тэг /гээд найзууддаа өгөх 7 витаминг нэг талын гарт нь бариулаад энийг найзууддаа өгөөрэй за

Ү: За багшаа

Б: /нөгөө гарт нь үлдсэн нэг витаминг тавиад нэмээд 4 витамин тавиад/ Энийг өөрөө л иднэ шүү за юу

Ү: За баярлалаа багшаа хэмээн их л баярлан инээд алдаад гарлаа Удалгүй араас нь гартал найзууд нь тойроод зогсцон витаминаа тараан зогсохдоо сая чамд өгсөн үү хэмээн лавлан зогсох нь тэр шүү.





Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# БИДНИЙ ӨДРҮҮД

Зарим жаахнууд маань ханиад хүрээд утлага эмчилгээнд орж байгаа.

Хөл хорионы үед үйлчлүүлэгчид маань Д3 витамин болон зестомин, натурвит зэрэг витаминууд ууж байлаа. Мөн өдөр болгон халуун чацаргана, аарц, нэрс буцалгаж халуун юм сайтар ууж дархлаагаа дэмжиж байлаа.

Түр хамгаалах байрны ажилчид маань долоо хоног болгоны нэг өдөр 1 цаг хүүхдүүдтэйгээ хөгжөөн баясгах үйл ажиллагаа явуулан цагийг өнгөрөөдөг. /4-8 настнуудын бүтээл /



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ

# БИДНИЙ ӨДРҮҮД

Тогтмол маск зүүж, 2 цаг тутам биеийн халуун үзэж, өглөө өдөр орой повидон иод болон содын уусмалаар хоолойгоо тогтмол зайлж байлаа.



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ



Санхүүгийн тайлан  
мэдээ

# ХОЦРОГДОЛ АРИЛГАХ СУРГАЛТ

## Тайлбар

Энэ сард нийтдээ 16 сурагч хичээлийн хоцрогдол арилгах сургалтанд хамрагдлаа. Тус сурагчид нь теле болон онлайн хичээлдээ тогтмол хамрагдаж, даалгавар дасгал тогтмол ажиллаж байна.

6-9 насны 2 сурагч нь 9 сараас эхлэн Монгол хэл болон Математикийн хичээлд анхан шатны зурлаганаас эхэлж байсан бол энэ сард 35 үсгээ үзэж дуусган, дуртай номоо уншин, 1-100 дотор бодож чаддаг болжээ.



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ

Санхүүгийн тайлан  
мэдээ



# ЗОХИОН БИЧЛЭГ

## Тайлбар

Мөн өөрсдийн уншсан номын тэмдэглэлийг тогтмол хөтөлж байгаа бөгөөд хамгийн их номыг 11-р ангийн сурагч маань зөвхөн 4 сард гэхэд 10 ном уншиж тэргүүлж байна. уншсан номын гол дүрээ дэвтэртээ буулган, бусдадаа гол утга санааг нь ярьж өгөв.

Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаагаар калимба хөгжим тоглоцгоосон. Бүгд л дуугаралтыг нь сонсон, биширч, өөрсдөө ая оруулж үзээд бүр их баярлацгааж байсан. Ийм гоё хөгжим явуулсан ах эгч нартаа маш их баярлалаа хэмээн дамжуулсан шүү.

Бага ангийн сурагчдад бидний мэдэх үсгээ хэрхэн зураг болгон амилуулж болох вэ хэмээн сонирхолтой хичээл орсон. Хүүхэд бүр идэвхитэй сайн оролцож, хөгжиж байна



Ид шидтэй ах эгч  
нарын мэдээ

Номын сангийн  
мэдээ


Санхүүгийн тайлан  
мэдээ

# ЗОХИОН БИЧЛЭГ

## Тайлбар

Ахлах ангийн сурагчдын зохион бичих чадварыг сайжруулах зорилгоор тогтмол эх зохиолгож байна. Үгийн тоо доод тал нь 100 гэхэд 10 үгтэй зохион бичиг хийж ирээд “Өөр үг олдохгүй байна. зохиолчид яаж ийм их үгийг зохиож бичдэг байна” хэмээн гайхаад зогсож байх юм.

“Миний дүү” сэдэвт эх зохиох даалгавар гэрт өгөхөд нэгэн сурагч маань өөрийн хайртай дүүгээ үргэлж хүчирхийлэл айдас бүхнээс хамгаална хэмээн бичсэн байна.



## Ид шидтэй ах эгч нарын мэдээ

ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ  
Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал  
Цэцэрлэгийн хангамжийн зардал  
Сургалт, судалгаа, хөгжүүлэлтийн хэрэглэгдэхүүний зардал

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ  
Хамгаалах байрны хүүхдийн хоолны зардал  
Хамгаалах байрны хүүхдийн хувцас зардал  
Хамгаалах байрны хүүхдийн ахуйн хэрэглэлийн зардал  
Сэтгэл заслын үйлчилгээний зардал  
Хүүхэд хамгааллын нийгэмшүүлэх үйлчилгээний зардал  
Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрүүл мэнд эм хангамж зардал  
Хүүхэд хамгааллын үйлчилгээний хангамж зардал/ үс зөмөх анги цэрэрлгээ хуримтлал  
Бичиг хэргийн зардал  
Томилолтын зардал  
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал

### АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ

Цахилгаан  
Бохир ус  
Цэвэр ус  
Хог тээвэр  
Интернет  
Утас ид шидийн орон  
Утас хамгаалах байр

### ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

Цалингийн зардал /хамгаалах байр /  
Цалингийн зардал /Ид шидийн орон нэг /  
Цалингийн хуримтлалын зардал  
НДШ-ийн зардал /нийт цалин/

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Ажилчдын хоолны зардал  
Маркетингийн зардал  
Ногоон байгууламжийн арчилгааны зардал  
Цэвэрлэгээ, ариутгалын зардал  
Берилгын засварын зардал  
Тоног төхөөрөмжийн засварын зардал  
Шатахууны зардал  
Тээврийн зардал  
Шатахууны зардал ид шидийг орон нэг  
Тээврийн зардал ид шидийн орон нэг  
Томилолтын зардал ид шидийн орон нэг  
Бичиг хэргийн зардал ид шидийн орон нэг  
Сургалтын зардал  
Unifonm, үнэмлэх гм  
Төтварын зардал Үл хөдлөх, газар  
Дэвтгэлийн зардал

### НЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал  
Бусад зардал \нотариат, орчуулга, карго\

## Номын сангийн мэдээ

ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ - 125%

11,795,488 ₮

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЗАРДАЛ - 25%

2,358,800 ₮

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН  
ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ - 23%

2,189,407 ₮

АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ  
1,7%

162,500 ₮